

**Увс аймгийн Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бие даан
нэр дэвшигч Мунан овогтой Сарантуяагийн 2020 – 2024 онд хэрэгжүүлэх
мөрийн хөтөлбөр**

Нэг: Шудрага ёсыг тогтоож, иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ – иргэн – төрт ёсны уламжлалыг дээдлэн ажиллаж нийгмийн хариуцлагын түвшинг сайжруулна

- 1.1. Төрийн албанд намчирхах үзлийн эсрэг тууштай тэмцэж сургууль төгссөн залуу боловсон хүчний томилгоог хараат бус болгож нээлттэй сонгон шалгаруулалтаар ажилд томилуулахад анхааран ажиллана.
- 1.2. Төрийн үйлчилгээг ард иргэдэд хурдан шуурхай хүргэх, нийгмийн хариуцлагын хүрээнд чадварлаг боловсон хүчин, технологийн дэвшил, судалгаа, хууль эрх зүйн шинэчлэлийг хийж Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн ойлголтыг өөрчлөн ажиллана.
- 1.3. Хууль гажуудуулж, хуулийг уландаа гишгэсэн төрийн албан хаагчдад хариуцлага нэхэхийг шаардаж ажиллана.
- 1.4. Аливаа төсөл төндөрийн шалгаруулалт, бараа үйлчилгээний худалдан авалт, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидэд очих зээлийн журмын хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж сайжруулан ил тод нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэн ажиллана.
- 1.5. Төрийн албан дахь хүнд суртал, харицлагагүй байдалд дүгнэлт хийж орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн эрх ашиг нэгдүгээрт байх зарчмыг баримтлан ажиллана.
- 1.6. Зүүнхангай суманд гарч байгаа гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт, зөрчил, гомдлыг шуурхай шалгуулж иргэдийн дуу хоолой болж ажиллана.

Хоёр: Хөгжих боломжтой иргэдийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлж чинээлэг дундаж орлоготой давхарга бүрдүүлэхийн төлөө ажиллана.

- 2.1. Орон нутгийн гар урлалыг салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан ард иргэдээр хэлэлцүүлэн төсөл хөтөлбөрт хамруулан орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.2. Ахуйн үйлчилгээ – ажлын байр дэд хөтөлбөр боловсруулан ажлын байрыг нэмэгдүүлж ахуйн үйлчилгээний 2 байрыг ашиглах боломжийг бүрдүүлж ажиллана.
- 2.3. ЖДҮ – ийг дэмжих сангийн зээлэнд хяналт тавьж хавтгайруулан жижиг төсөл хэлбэрээр иргэдэд олгож байгаа хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож шаардлага хангасан ажлын байранд олгоход хяналт тавина.

2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох боломж бүрдүүлнэ. Тэдэнд ажлын байр бий болгох хамтран ажиллах нөхцлийг дэмжинэ.

2.5. Малчдын болон эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж санал хүсэлтийг нь сонсож ажил хэрэг болгож ажиллах ажлыг чанартай хийж гүйцэтгэнэ.

2.6. "Сумандаа сайхан амьдрая" төсөл хэрэгжүүлнэ.

2.7. Сумын брэнд бүтээгдэхүүнийг худалдаалах үзэсгэлэн худалдааг жилдээ 1 - 2 удаа Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын нутгийн зөвлөлийнхөнтэй хамтран зохион байгуулж малчид, иргэдийн үйлдвэрлэсэн сүү сүүн болон мах, махан бүтээгдэхүүн гар урлалын чиглэлээр брэндүүдийг бий болгож худалдаалах сүлжээг бий болгон ажиллана.

2.8. Эмзэг бүлгийн иргэдийн чадавхийг сайжруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулж төсөл хөтөлбөрт хамруулна.

2.9. Ард иргэдийг бүлэг, хоршоо болон хамтын хүчээр бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж дэмжлэг үзүүлэн ажиллана.

Гурав: Нийгмийн бодлогын дараах гол салбаруудын үйл ажиллагааг ард иргэдэд хүргэх үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарал хандуулна.

3.1. "Бие эрүүл иргэн", "Боловсролтой иргэн" төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1. Хүн бүрийг эрүүл амьдрах арга ухаанд сургах сургалт, дасгал хөдөлгөөн зэрэг нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж ажиллана.

3.1.2. Сумын ард иргэдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилт хэрхэн байгаад хяналт тавьж ажиллана.

3.1.3. Сум багуудыг холбосон оношлогоот эмчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээний сүлжээ бий болгоно.

3.1.4. Эмч нарыг мэргэшүүлэх, сумын эрүүл мэндийн төвдөө анхан шатны эмчилгээ үйлчилгээг хийж иргэдийн явдал чирэгдлийг багасган ажиллахад анхаарна.

3.1.5. Суманд ажиллахаар ирсэн эмч, эмнэлэгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах талд анхаарал хандуулна.

3.1.6. Малчдын эрүүл мэндийн үзлэг оношлогоог тогтмол болгох багийн эмч нарын багтаа ажиллахгүй чирэгдэл учруулдаг хариуцлагагүй байдлыг таслан зогсоох арга хэмжээг авч ажиллана.

3.1.7. Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагагүй байдлыг сайжруулах, ард иргэдэд хүрэх үйлчилгээг ил тод болгоход анхаарна.

3.1.8. Боловсролын байгууллага дахь хүүхдийн хүчирхийлэл,хараа хяналтгүй байдал, ялгаварлан гадуурхах байдлыг таслан зогсоож” Хүүхэд нэг бүрт хүртээмжтэй боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.9. 21 дүгээр зуун – бүтээлч сэтгэлгээтэй иргэн хөтөлбөрийг боловсруулан хүүхдэд багаас нь амьдрах арга ухаан,аж төрөх арга ухаан,бие хүн болон төлөвших арга ухааныг суралцуулах,орчин үеийн техник технологийн эрин зуунд хөл нийлүүлэн алхах мэргэжилээ зөв сонгох арга зүйд сургах үйл ажиллагааг багш нартай хамтран хэрэгжүүлнэ.

3.1.10. Сумын нийт иргэд, хүүхэд багачуудын дунд “ Хүн хөгжлийн төв” сургалт арга зүйн төвийг шинээр нээж эрүүл зөв амьдрах аргад хамтаараа суралцах нөхцлийг бүрдүүлнэ.

3.1.11. Хүүхдийн хөгжил,оролцоог дэмжих замаар гэр бүл, нийгмийн хөгжлийн таатай болгоход чиглэсэн үйлчилгээ,хамтын ажиллагааг өргөжүүлэн,хүүхдийн үндсэн эрхийг хангах төрийн үйлчилгээг хүртээмжтэй,чанартай,түргэн шуурхай хүргэж хууль тогтоомжийн хэрэгжүүлэхэд оролцоно.

Дөрөв: Эрүүл аюулгүй орчинд тухтай зөв боловсон амьдрах” Бохирдолгүй ирээдүй” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

4.1. “Архигүй ирээдүй гоё” аяныг зохион байгуулж сумаараа архидалтын түвшинг бууруулан ажиллана.

4.1.1. Сумын хэмжээнд зөвшөөрөл авсан маш олон архины зөвшөөрлийг эрс багасгаж 7 хоног бүрийн 5 дахь өдөр архи зарахгүй байх зарчмыг баримталж хэрэгжүүлнэ.

4.1.2. Архидан согтуурч нийгмийн хэв журмыг зөрчсөн иргэдээр нийтийн хөдөлмөр хийлгэх арга хэмжээг сумын хэв журмыг хамгаалах зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.

4.1.3. Архидалтын улмаас гэр бүлийн хүчирхийлэл их гарч байгаад дүгнэлт хийж сургалт суртчилгаа хийж ажиллана.

4.2. Эрүүл аюулгүй орчинд тав тухай амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

4.2.1. Сумын ард иргэдэд сэтгэлгээний шинэчлэл хийх,нийгмийн тогтолцооны шилжилтэнд тогтоцтой өөрчлөгдөж,сум орны хөгжил, удирдлагын түвшинд хайнга хандаж байгаатай тууштай тэмцэж үүнээс улбаалах сүүдэртэй тал улам газар авч гэмт хэрэгжих,шоронжих,ёс суртахуун ялзрах үзэгдэл газар авч нийгмийн оюун санааны үнэт зүйлс балартаж, хайрлах,шүтэх,бахархах ариун үнэлэмж хээгүй бүдүүлэг авирлал,өнгө мөнгөний улайралд идэгдэн бүдгэрч байгааг өөрчлөнө.

4.2.2. Эмзэг бүлгийн иргэдийн чадавхийг сайжруулах бусдын адил ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

4.2.3. Хог хаягдлын менежментийг сайжруулах, хоггүй цэвэр орчинд амьдрах “Сумын соёл” мэдээллийн цагийг тогтмол зохион байгуулж дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

Мэдээллийг бэлтгэсэн :

Бие даан нэр дэвшигч М. Сарантуяа